

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудасны дугаар</b>
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-21
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	22-103
	1.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	22-63
	2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/	63-76
	3.Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Гадаад худалдааны бодлого, зохицуулалтын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох	76-94
	4.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газраас 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	94-97
	5.“Музейн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2020.05.01-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	97-99
	Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсгох	99-101

## **Хураангуй тэмдэглэл**

**Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцэслэн батлах/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т “Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**Г.Занданшатар:** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 2

Бүгд: 52

96.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

### **Хамт өргөн мэдүүлсэн:**

1.Монгол Улсын шүүхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 3

Бүгд: 52

94.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 2

Бүгд: 52

96.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 4

Бүгд: 52

92.3 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 5

Бүгд: 51

90.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

17.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

18.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

20.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

21.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

22.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 4

Бүгд: 51

92.2 хувийн буюу олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг эцэслэн баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлж, Шүүхийн шинэтгэлийн хуулийг амжилттай хэрэгжүүлэхийг хүсэн ерөөв.

*Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.*

### **Дэлгэрэнгүй тэмдэглэл**

**Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалтууд явуулна.**

Байнгын хороо эцэслэн батлуулах төслийн хувилбарыг бэлтгэж гишүүдэд тараасан байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаан хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхын санал талаар дэмжигдсэн бол хуулийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Ингэхээр одоо нийт гишүүдийн буюу 76 гишүүний 39-өөс дээш гишүүний саналаар хууль эцэслэн батлагдана.

1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

Санал хураалт

“Их хуралдай” танхим Монгол Ардын намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн.

**Д.Тогтохсүрэн:** 22 гишүүн санал хураалтад оролцож 19 гишүүн дэмжсэн байна.

“Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** Санал хураалтад 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 11 гишүүнээс 11 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийг “Үндсэн хууль” танхимын 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхимд 6 гишүүнээс 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 52 гишүүн оролцож, 50 гишүүн дэмжиж хуралдаанд оролцсон гишүүдийн 96.2 хувийн саналаар Улсын Их Хурлын нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар буюу 50 гишүүний саналаар хууль эцэслэн батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт

“Их хуралдай” танхим, эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн.

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн санал хураалтад оролцож 18 гишүүн дэмжсэн байна.

“Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** Санал хураалтад 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас оролцсон 11 гишүүнээс 11 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** “Үндсэн хууль” танхимын 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүнд баярлалаа. “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 6 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэлд баярлалаа.

Санал хураалтад 52 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжиж нийт гишүүдийн олонхоос дээш саналаар энэ хууль эцэслэн батлагдлаа.

2.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Эрхэм гишүүн дуламдоржийн Тогтохсүрэн

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** Тогтохсүрэн дарга аа, сүүлд нь маргаангүйн тулд яг тоолчихъё. 18 байх шиг байсан.

“Их эзэн Чингис хаан” танхим эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин

**Г.Амартүвшин:** 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа

**Х.Булгантуяа:** 11 гишүүнээс 11 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 100 хувь дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 7-гоос 6 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 52 гишүүн оролцож, 49 гишүүн дэмжлээ. Энэ хууль эцэслэн батлагдлаа.

3.Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар

**Ж.Сүхбаатар:** “Үндсэн хууль” танхимын 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 7-гоос 6 дэмжиж байна.



**Г.Занданшатар:** Санал хураалтад 52 гишүүн оролцож, 48 гишүүн дэмжлээ. Хууль эцэслэн батлагдлаа.

4.Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхимын эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин

**Г.Амартүвшин:** 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Эрхэм гишүүн дуламдоржийн Тогтохсүрэн

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль”

**Ж.Сүхбаатар:** 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

6.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томёоллоор санал хураалт явуулъя.

Эрхэм гишүүн дуламдоржийн Тогтохсүрэн “Их хуралдай” танхимаас

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхимаас Ганибалын Амартүвшин гишүүн

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

7.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Эрхэм гишүүн дуламдоржийн Тогтохсүрэн “Их хуралдай” танхимаас

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхимаас эрхэм гишүүн Ганибалын Амартүвшин гишүүн

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим эрхэм гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар

**Ж.Сүхбаатар:** “Үндсэн хууль” танхимын 6 гишүүн санал нэгтэй дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

8.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна, “Их хуралдай” танхимд.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

9.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

**Д.Тогтохсүрэн:** “Их хуралдай” танхим 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

10.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** “Их хуралдай” танхим 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6-уулаа 100 хувь дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

11.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

**Д.Тогтохсүрэн:** “Их хуралдай” танхим 21 гишүүнээс 17 гишүүн уг хуулийг дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6-уулаа 100 хувь дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

12.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

13.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

14.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүнээс 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, энэ хууль эцэслэн батлагдлаа.

15.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** Санал хураалтад 21 гишүүн оролцож уг хуулийн төслийг 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** “Үндсэн хууль” танхимын 6 гишүүн 6-уулаа 100 хувь дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

16.Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн.

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн санал хураалтад оролцож 17 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** 18 дэмжсэн дээ, намайг оруулаагүй байна.

“Их эзэн Чингис хаан” танхимаас

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн

**Х.Булгантуяа:** 10 гишүүн оролцож 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** Үлгэр жишээ “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 гишүүн дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 46 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

17.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

“Их хуралдай” танхим эрхэм гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн.

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүнээс 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүнээс 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

18.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн оролцож, 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

20.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн оролцож, 6-уулаа дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим



**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

21.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүн санал хураалтад оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн оролцож 6 гишүүн дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

22.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

“Их хуралдай” танхим

**Д.Тогтохсүрэн:** 21 гишүүн гишүүн санал хураалтад оролцож, 18 гишүүн дэмжсэн байна.

**Г.Занданшатар:** “Их эзэн Чингис хаан” танхим

**Г.Амартүвшин:** 8 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Жанжин Д.Сүхбаатар” танхим

**Х.Булгантуяа:** 10 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжлээ.

**Г.Занданшатар:** “Үндсэн хууль” танхим

**Ж.Сүхбаатар:** 6 гишүүн оролцож 100 хувь дэмжиж байна.

**Г.Занданшатар:** “Их засаг” танхим

**О.Цогтгэрэл:** “Их засаг” танхим 6-гаас 5 дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Санал хураалтад 51 гишүүн оролцож, 47 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Эрхэм гишүүд ээ, та бид Шүүхийн тухай хуулийг эцэслэн баталлаа. Эрхэм гишүүд, ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлье. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах эрх зүйн хувьсгал хийж, иргэд шударга шүүхээр шүүлгэх эрхээ хангах эрхэм зорилго бас нэг шатаар урагшиллаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үндсэн зорилтын нэг нь шүүх шүүгчдийн хараат бус, бие даасан байдлыг хангах, үүгээр дамжуулан шударга ёсыг тогтоох явдал байсан. Шүүхийн тухай энэ хуулийг эцэслэн батлахад Улсын Их Хуралд суудалтай бүх намууд, бие даагчид онцгой хүчин чармайлт гаргаж, ойлголцол зөвшилцлийг эрхэмлэж, нийгмийн шударга ёс тогтоох эрхэм зорилгод нэгдэж, Үндсэн хуульд өргөсөн тангарагтаа үнэн ч байж, шүүхийн шинэтгэлийн төлөө нэг санаа, нэгдмэл зорилготой ажилласан явдалд гүн талархал илэрхийлж байна.

Түүнчлэн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал болон олон улсын сайн туршлага, жишигт нийцүүлэх, иргэд, олон нийт, хуульчид, мэргэжилтнүүдийн шүүгчдийн судлаачдын санал, зөвлөмжийг тусгах, улам чамбайруулах чиглэлээр хичээн зүтгэсэн Сандагийн Бямбацогт даргатай Хууль зүйн байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн ахлагч Баттөмөрийн Энхбаяр нарын гишүүдэд нийт гишүүдийнхээ өмнөөс талархал илэрхийлж, баяр хүргэе.

Энэ хуулиар Үндсэн хуулиар олгогдсон иргэдийнхээ шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангалаа, иргэдийг эрүүдэн шүүх, хууль бусаар яллах зэрэг хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зохицуулалтуудыг орууллаа. Шүүх эрх мэдэл, түүний хараат бус байдалд хэн нэгэн нөлөөлөх эрх мэдэл тогтоохоос сэргийлж, олон талын оролцоо, хяналт тэнцлийг тогтоолоо. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий шүүхийн сахилгын хороотой байхаар тусгаж, эрх, үүргийг тодотголоо. Улсын дээд шүүх, шүүхийн ерөнхий зөвлөлийн болон сахилгын хорооны шүүгчдийг сонгохдоо ил тод сонгон шалгаруулах зарчмыг баримтлах, нийтийн сонсгол хийх, нэр дэвшигчдийн талаар иргэд санал бодлоо илэрхийлэх замаар шударга ёсыг хангах, шүүхэд шатлан дэвших зарчмыг хэрэгжүүлэх шинэ тогтолцоог бүрдүүллээ. Нийтийн сонсгол бол иргэдийн оролцоотой, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотой, ард түмний дунд хэлэлцэгчдийн яригдаж байгаа хэргийг олон нийтийн сонсголоор, ард түмний оролцоотойгоор шийддэг ийм ардчиллын шударга хэлбэр гэж үздэг ээ. Энэ шүүлтүүрээр орж сонгогддог боллоо.

Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгч бас таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулж, томилох, нэр дэвшигчдийг томилгооны сонсголоор заавал оруулахыг заасан нь Үндсэн хуульд заасан Үндсэн хуулийн 3.1, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан ард түмний мэдэх эрх, оролцоог хангаж буй чухал зохицуулалт боллоо. Шүүгчид нэр дэвшигчээс хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт төдийгүй мэргэшил ёс зүй, зан төлөвийн шалгалт авах, эдгээр шалгалтын аль алинд нь тэнцэж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилох боллоо.

Эдгээр өөрчлөлтүүд хэрэгжсэнээр шүүх болон шүүгчийн хараат бус байдал хангагдаж, улс төр, бизнесийн аливаа нөлөөлөлд орохоос сэргийлэх нөхцөл бүрдэнэ. Шүүгчид ёс зүйн болон эрх зүйн хариуцлага хүлээлгэх үр нөлөөтэй тогтолцоо бүрдэнэ. Хамгийн чухал нь Монгол Улсад хуулийн засаглал, шударга

ёсонд ноёрхох суурь нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Улмаар хууль нь ярьдаггүй шүүх, шүүгч нь ярьдаг хууль байх сонгодог зарчим тогтоно. Эрх зүйн хувьсгалын нэг үндсэн зорилго нь үүнд л чиглэж байгаа юм. Мэдээж хуулийн үр дагавар нэг өдөр цэцэглээд шууд хэрэгжчихгүй тодорхой хугацаа шаардана. Энэ хуулийн шинэтгэлийг шүүхийн шинэтгэлийг бодитой хэрэгжүүлэхэд шүүгчдийн төдийгүй хүн бүрийн хүчин зүтгэл онцгой чухал үүрэг рольтой. Энэ хуулийг амьдралд бодитой хэрэгжүүлэх хэрэгтэй. Хуулийг хэрэгжүүлэхэд бүх шатны шүүхийн байгууллага, шүүгчид онцгой чухал үүрэгтэй гэдгийг эцэст нь тэмдэглэж хэлье.

Энэ хуулийг батлахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан Шүүхийн тухай багц хуулиудын үзэл санаа, зүйл заалтуудаас 98 хувийг нь оруулж тусгалаа гэдгийг ажлын хэсэг албан ёсоор мэдэгдсэн. Мөн шүүгчид, Дээд шүүгчдийн төлөөлөл ажлын хэсэгт орж, шүүгчдийн байр сууриа тодорхой илэрхийллээ. Энд Хууль зүй, дотоод хэргийн яам хууль санаачлагчийн хувьд идэвхтэй оролцлоо. Манай Төрийн нарийн бичгийн дарга Баасандорж, Хууль зүйн бодлогын газрын дарга Пүрэвжавын Сайнзориг, хууль зүйн ухааны доктор Одонхүүгийн Мөнхсайхан нар бас онцгой хүчин чармайлт гаргаж, мөн Дээд шүүхийн шүүгч Цэндийн Цогт нар бас онцгой чармайлт гаргаж ажилласанд талархал илэрхийлж байна.

Шүүхэд хийх шинэтгэлийн зорилт үр дүнд хүрэх нь та биднээс, нийт шүүгчдээс бас ихээхэн хамаарна. Ийм учраас энэ өдрөөс эхлээд шинэ дэг журам тогтож байгаа гэдгийг хаа хаанаа сайн ойлгож, энэ шүүхийн шинэтгэлийн үзэл санааг амьдралд хэрэгжүүлэхийн төлөө санаа нэгдэж ажиллахыг уриалж байна. Тиймээс эрх мэдлийн ариун журамт үүрэг Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж, хэрэг маргааныг хэнээс ч хараат бус зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд захих тангаргаа эрхэмлэн дээдэлж, сахин биелүүлж ажиллахыг нийт шүүгчдэдээ сануулж хэлье. Нийт Улсын Их Хурлын гишүүддээ ч гэсэн шүүхийн хараат бус байдал, эдийн засгийн баталгааг хангах талаар идэвх санаачилгатай ажиллаж байхыг уриалъя.

Ингээд шүүхийн шинэтгэлийн хуулийг амжилттай хэрэгжүүлэхийг та бүхэндээ хүсэн ерөөе. Баярлалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Лхүндэвийн Атарцэцэг, Хууль зүйн яамны Цолмон нар бас ажлын хэсэгт идэвхтэй ажилласныг эцэст нь тэмдэглэж байна.

Ингээд асуулгын цаг орно. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн тав дахь өдрийн үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайдын асуулгын хариултыг сонсоно.

Асуулгын хариултыг сонсох ажилд бэлдье.